

Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагаа

MNS 6980:2022

Албан хэвлэл

Стандарт, хэмжил зүйн газар

Улаанбаатар хот

2022 он

MNS 6980:2022

ӨМНӨХ ҮГ

Стандарт хэмжил зүйн газар нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

Тус Газар нь тухайн салбарын үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хорооны хэлэлцэж, зөвшилцсөн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэ стандартыг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн дарга, хошууч Ч.Лхамжав боловсруулсан.

Энэ стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Шуудангийн хаяг

Улаанбаатар-13343, Ш/Х - 48

Утас: 976-51-263860 Факс: 976-11-458032

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2022

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

Агуулга

Хуудас

Өмнөх үг	3
Танилцуулга	4
1. Хамрах хүрээ	5
2. Норматив эшлэл	6
3. Нэр томъёо, тодорхойлолт	6
4. Зарлан мэдээллийн ангилал, дамжуулах хэлбэр.....	13
5. Зарлан мэдээлэх үйл ажиллагааны ерөнхий шаардлага.....	15
6 Хавсралтууд	17
7. Ном зүй.....	19

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.200

Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагаа	MNS 6980:2022
Operations on disaster warning system	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн С/39 дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь Онцгой байдлын байгууллагаас гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах, дадлага сургууль зохион байгуулах, зарлан мэдээллийн системийн техникийн туршилт хийх үйл ажиллагаанд хамаарна.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

MNS 6010:2016, *Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт*

MNS 4979:2016, *Тээврийн хэрэгсэлд ашиглах дуут болон гэрлэн дохио. Ерөнхий шаардлага*

MNS 6607:2016, *Өргөн нэвтрүүлгийн үгэн болон урсдаг мэдээллийн форматад тавих шаардлага*

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

дохио

дуу, дүрс болон бичвэр (үсэг, тоо, тэмдэгт), тодорхой өнгө бүхий гэрэл

3.2

түгшүүрийн дохио

“Улаан” түвшний үед дамжуулах дохио

3.3

сэрэмжлүүлэх дохио

“Улбар шар” болон “Шар” түвшний үед дамжуулах дохио

3.4

сургалтын (тайван цагийн) дохио

“Ногоон” түвшний үед дамжуулах дохио

3.5

зарлан мэдээлэл дамжуулах үйл ажиллагаа

аюулын дүн шинжилгээ хийх хэсгээс хүлээн авсан нотолгоонд суурилсан мэдээлэлд үндэслэн эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүст шаардлагатай мэдээллийг хүргэх үйл ажиллагаа

3.6

аюул өнгөрсөн тухай мэдэгдэл

аюул өнгөрч тайван байдалд шилжсэн тухай мэдэгдэл

3.7

сэрэмжлүүлэх мэдээлэл

гамшиг, аюулт үзэгдэл, ослын өмнө эрсдэлтэй нөхцөлд байгаа иргэдийг үүсэж болзошгүй нөхцөл байдал, шаардлагатай шийдвэр, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллээр хангах бүх нийтийн зарлан мэдээлэл

3.8

эрсдэлтэй нөхцөлд байгаа иргэд

гамшиг, аюулт үзэгдэл, осолд өртөж болзошгүй иргэд

3.9

зарлан мэдээллийн систем

зарлан мэдээллийн систем нь аюулыг ойлгох, зураглах, болзошгүй аюулын нөхцөл байдлыг үнэлэх, хянах, шинжлэх, урьдчилан мэдээлэх, иргэд, олон нийтэд хүргэх зарлан мэдээллийг дамжуулах, шуурхай хариу арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааны цогц хэлхээ

3.10

өнгөний код

тодорхой утгыг илэрхийлэхийн тулд ашиглаж буй өнгө

3.11

“Улаан” түвшин

гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүсэж болзошгүй эсвэл үүссэнийг илтгэх бөгөөд эрсдэлтэй нөхцөлд байгаа иргэдэд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх, аюулгүй газарт шилжин очихыг мэдэгдэж буй зарлан мэдээллийн хэлбэр

3.12

“Улбар шар” түвшин

гамшгийн онцгой нөхцөл байдал үүсэж болзошгүй эсвэл үүссэнийг илтгэх бөгөөд эрсдэлтэй нөхцөлд байгаа иргэдэд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авахыг мэдэгдэж буй зарлан мэдээллийн хэлбэр

MNS 6980:2022

3.13

“Шар” түвшин

аюултай нөхцөл байдал үүсэж болзошгүй эсвэл үүссэнийг илтгэх бөгөөд эрсдэлтэй нөхцөлд байгаа иргэдэд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авахыг анхааруулж буй зарлан мэдээллийн хэлбэр

3.14

“Ногоон” түвшин

аюул өнгөрсөн тухай мэдэгдлийг илэрхийлж буй зарлан мэдээллийн хэлбэр

Мөн сургалт дадлага, системийн техникийн туршилт явуулахыг мэдэгдэж буй зарлан мэдээллийн хэлбэр

3.15

зурвасын өргөн

герцээр илэрхийлэгдсэн орчноор мэдээлэл дамжуулах багтаамж, сигналын давтамжийн хязгаар

3.16

децибел (дБ)

сигналын чадлын харьцангуй хүчдэлийг хэмжих логарифмик нэгж

3.17

герц (Гц)

үелэн тохиолдож буй үзэгдлийн 1 секундэд тохиох давтамжийн тоо

4 Зарлан мэдээллийн ангилал, дамжуулах хэлбэр

4.1. Зарлан мэдээллийн дохиог зарлан мэдээллийн цамхаг, техник хэрэгслээр дамжуулах төрлөөр 1 дүгээр хавсралтаар тодорхойлсон.

4.1.1 “Улаан” түвшний үед түгшүүрийн дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “*Анхаараарай, Анхаараарай, Анхаараарай ... (мэдээллийн товч утга)*... *Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)*” гэсэн загвараар тодорхой давталттай хүргэнэ.

4.1.2 “Улбар шар” түвшний үед сэрэмжлүүлэх дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “*Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)*... *Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)*” гэсэн загвараар тодорхой давталттай хүргэнэ.

4.1.3 “Шар” түвшний үед сэрэмжлүүлэх дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “*Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)*... *Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)*” гэсэн загвараар тодорхой давталттай хүргэнэ.

4.1.4 “Ногоон” түвшний үед:

- Аюул өнгөрсөн тухай зөвлөмж хүргэх үеэр сургалтын дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “*Онцгой байдлын ерөнхий газраас мэдээлж байна ... (мэдээллийн товч утга)*”;
- Сургалт, дадлагын үеэр зарлан мэдээллийн дохио дамжуулах дарааллыг 2 дугаар хавсралтад зааснаар;
- Системийн техникийн туршилт хийх үеэр сургалтын дохиог 60 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “*Зарлан мэдээллийн системийн техникийн туршилт явагдаж байна*” гэсэн мэдээллийг тодорхой давталттай дамжуулна.

4.2 Зарлан мэдээллийн дохиог телевизээр дамжуулах (1 дүгээр хавсралт)

4.2.1 “Улаан” түвшний үед түгшүүрийн дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргахтай зэрэгцүүлэн эфирт бүтэн дэлгэцээр зарлан мэдээллийг хүргэх ба дэвсгэрийн өнгө улаан, бичвэрийн үсгийн өнгө хар байна.

Улаан өнгөний код: RGB 255/0/0

Хар өнгөний код: RGB 0/0/0

4.2.2 “Улбар шар” түвшний үед эфирт дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө улбар шар, бичвэрийн үсгийн өнгө хар байна.

Улбар шар өнгөний код: RGB 240/140/17

Хар өнгөний код: RGB 0/0/0

4.2.3 “Шар” түвшний үед эфирт дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө шар, бичвэрийн үсгийн өнгө хар байна.

Шар өнгөний код: RGB 244/207/0

Хар өнгөний код: RGB 0/0/0

4.2.4 “Ногоон” түвшний үед эфирт дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө ногоон, бичвэрийн үсгийн өнгө хар байна.

Ногоон өнгөний код: RGB 0/160/60

Хар өнгөний код: RGB 0/0/0

Зурвасаар урсах бичвэрийн үсгийн фонтыг нь ердийн “Arial” байна. Фонтын үсгийн өндөр нь 18~20 хэмжээтэй байна. Бичвэрийн урсан өнгөрөх хурд нь үзэгч уншиж гүйцэхүйц буюу нэг минутад 250~275 тэмдэгт буюу 50~55 үг байна.

4.3 Зарлан мэдээллийн дохиог радиогоор дамжуулах (1 дүгээр хавсралт)

4.3.1 “Улаан” түвшний үед “*Анхаараарай, Анхаараарай, Анхаараарай ... (мэдээллийн товч утга)*... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.

4.3.2 “Улбар шар” түвшний үед “*Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)*... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар тодорхой давталттай хүргэнэ.

MNS 6980:2022

4.3.3 “Шар” түвшний үед “Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар тодорхой давталттай хүргэнэ.

4.3.4 “Ногоон” түвшний үед:

- Аюул өнгөрсөн тухай зөвлөмж хүргэх үеэр “Онцгой байдлын ерөнхий газраас мэдээлж байна ... (мэдээллийн товч утга)”;
- Сургалт, дадлагын үеэр “Гамшигаас хамгаалах сургалт дадлага явагдаж байгаа тухай мэдээллийн товч утга” (2 дугаар хавсралт);
- Системийн техникийн туршилт хийх үеэр “Зарлан мэдээллийн системийн техникийн туршилт явагдаж байна” гэсэн мэдээллийг тодорхой давталттай дамжуулна.

4.4 Зарлан мэдээллийн дохионы нот

1. Улаан түвшний үед ашиглах түгшүүрийн дохионы нот:



2. Улбар шар, шар түвшний үед ашиглах сэрэмжлүүлэх дохионы нот:



3. Ногоон түвшний үед ашиглах сургалтын дохионы нот:



4.5 Түгшүүрийн дохио

Түгшүүрийн дохионы зорилго нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хүмүүсийн анхаарлыг татах, улмаар аюулгүй байдлаа хангах арга хэмжээ авахад чиглэнэ. Түгшүүрийн дохио дамжуулалт нь эрсдэлтэй нөхцөлд байгаа иргэд, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

4.6 Сэрэмжлүүлэх мэдээлэл

Сэрэмжлүүлэх мэдээллийн зорилго нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын өмнө үүсэж болзошгүй нөхцөл байдлыг даван туулах шийдвэр, аюулгүй байдлаа хангах зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэнэ. Сэрэмжлүүлэх мэдээлэл нь эрсдэлтэй нөхцөл байдалд орж болзошгүй иргэдэд зарлан мэдээллийн тохирсон хэлбэрээр цаг тухайд нь хүргэх шаардлагатай.

4.7 Хориглох зүйл


Зарлан мэдээллийн дуут дохиог тус стандартад зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

5 Зарлан мэдээлэх үйл ажиллагааны ерөнхий шаардлага

Дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх;
2. Зарлан мэдээлэл дамжуулах зорилтыг тодорхойлох, хянах тогтолцоог бүрдүүлэх;
3. Урьдчилан төлөвлөх, баримтжуулах, хэрэгжүүлэх, сайжруулах;
4. Зарлан мэдээллийн системийг төлөвлөх, хэрэгжүүлэх, ашиглалт үйлчилгээ явуулах, сайжруулах, хүний болон техникийн нөөцтэй байх;
5. Иргэд олон нийт, ялангуяа эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүст хүртээмжтэй байх;
6. Зарлан мэдээллийн дагуу хариу арга хэмжээний сургалтыг олон нийтэд зориулан зохион байгуулах;
7. Нийтийн ашиг сонирхолд нийцсэн байх;
8. Зарлан мэдээллийн системд оролцогч байгууллагууд өөрсдийн эрх, үүргийг мэддэг байх;
9. Зарлан мэдээллийн системд жилд нэгээс доошгүй удаа бүрэн хэмжээний туршилт, сургалт дадлага хийх;
10. Бүс нутгийн болон хил дамнасан аюулт үзэгдэл, гамшгийн үед зарлан мэдээллийг хөрш орнууд руу хүргэх үйл ажиллагааг тодорхойлох;
11. Сэрэмжлүүлэх мэдээлэл, түгшүүрийн дохио нь эрсдэлтэй нөхцөлд байгаа хүн амын хэрэгцээнд тохирсон байх /хэл, мэдлэг боловсрол, амьдралын хэв маяг, ёс заншил г.м/;
12. Зарлан мэдээлэх үйл ажиллагааны талаарх судалгаа, шинжилгээг тогтмол зохион байгуулж олон нийтийн мэдлэг, ойлголтын түвшинд дүн шинжилгээ хийх, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

5.1 Зарлан мэдээллийн системийн боловсруулалт



Зураг. Зарлан мэдээллийн системийн боловсруулалт

5.1.1 Зарлан мэдээллийг төлөвлөх

MNS 6980:2022

Аюулын дүн шинжилгээ хийх болон зарлан мэдээллийг дамжуулах гэсэн хоёр үндсэн чиг үүрэгт суурилсан үйл ажиллагааг төлөвлөнө.

Зарлан мэдээллийг төлөвлөхдөө дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

1. Зарлан мэдээллийг стандартын дагуу дамжуулахын тулд зарлан мэдээллийн системийн боломж, чадавхыг тооцох;
2. Эрсдэлийн шинж чанар, ноцтой байдлыг тодорхойлох;
3. Тухайн бүс нутгийн байгаль, газар зүйн онцлогийг харгалзах;
4. Зарлан мэдээллийн агуулгад аюулгүй ажиллагааны арга хэмжээг тусгах;
5. Эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүсийн судалгааг гаргах;
6. Цаг агаарын нөхцөл байдал, урьдчилсан мэдээг харгалзан үзэх.

Зарлан мэдээлэх арга зүйг боловсруулах, сонгохдоо дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:

1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал;
2. Онцгой нөхцөл байдал үүсэж болзошгүй цаг хугацаа;
3. Сэрэмжлүүлэх мэдээлэл хүлээн авах эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүс;
4. Аюулгүй байдлаа хангахын тулд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ;
5. Иргэд олон нийт зарлан мэдээлэл, зааварчилгааг хүлээн авч хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа;
6. Мэдээллийн хүртээмж, мэдээлэл хүлээн авснаар гарах эерэг үр дүн, зарлан мэдээллийн системийн техникийн найдвартай байдал;
7. Дамжуулсан мэдээллийг иргэд олон нийт, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн хүлээн авах боломж.

5.1.2 Зарлан мэдээллийн зорилтыг тодорхойлох

Дараах хүчин зүйлсийг харгалзан авч үзнэ. Үүнд:

1. Аюулын дүн шинжилгээний хэсэгт үнэлгээ хийсэн талаарх мэдээлэл;
2. Эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа иргэдэд хүргэх зарлан мэдээллийн төрөл, агуулга;
3. Зарлан мэдээллийг бүх нийтэд хүргэх арга зам;
4. Ашиглах боломжтой нөөцийн үнэлгээ;
5. Зарлан мэдээллийг дамжуулах цаг хугацаа;
6. Зарлан мэдээллийн системийн оролцогч талуудын зохицуулалт, хамтын ажиллагааны хэрэгцээний үнэлгээ.

5.1.3. Зарлан мэдээллийг хэрэгжүүлэх

Дараах хүчин зүйлсийг харгалзан авч үзнэ. Үүнд:

1. Зарлан мэдээллийг шуурхай дамжуулах;
2. Нотолгоонд суурилсан мэдээллийг түгшүүрийн дохио, сэрэмжлүүлэх мэдээлэл болгон гаргах;

3. Эрсдэлтэй нөхцөлд байгаа хүн ам, эмзэг бүлгийн иргэд болон тухайн орон нутагт түр оршин суугчдын мэдээллийн хэрэгцээг харгалзан үзэх, мэдээллийн агуулгыг нийцүүлэх;
4. Зарлан мэдээлэл дамжуулах чиг үүрэгтэй бусад байгууллагатай уялдаа холбоотой ажиллах, тэдний санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах;
5. Харилцаа холбооны олон сувгаар мэдээллийг дахин дамжуулах, тодорхой давтамжтайгаар дамжуулах огноо, цагийг тодорхойлох.

Зарлан мэдээллийг хэрэгжүүлэхдээ дараах асуултын дагуу мэдээллийн агуулгыг баталгаажуулна. Үүнд:

1. Зарлан мэдээллийг хэн дамжуулах ёстой вэ?
2. Мэдээллийг хэн авах ёстой вэ?
3. Зарлан мэдээллийг хэзээ дамжуулах вэ?
4. Хэн арга хэмжээ авах ёстой, яагаад арга хэмжээ авах шаардлагатай болох?
5. Ямар арга хэмжээг хэзээ, хэрхэн авах вэ?
6. Нөхцөл байдал өөрчлөгдөхөд юу хийх ёстой вэ?
7. Эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүс нэмэлт мэдээллийг хэрхэн авах вэ?

Зарлан мэдээллийг мэдээлэл, харилцаа холбооны боломжит бүх хэлбэрээр хүртээмжтэй хүргэх шаардлагатай. Үүнд:

1. Гар утасны мессеж;
2. Телевиз, радио;
3. Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхаг;
4. Дотоод зарлан мэдээллийн систем;
5. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл;
6. Зарлан мэдээллийн хөдөлгөөнт техник хэрэгсэл, автомашин;
7. Бие холбоочин.

5.1.4. Зарлан мэдээллийн системийг үнэлэх, сайжруулах

Аюулын дүн шинжилгээ болон зарлан мэдээлэл дамжуулах чиг үүргийн гүйцэтгэлийг тогтмол үнэлж байх ёстой.

Зарлан мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг үнэлэхдээ техник, технологийн чадавх, түгшүүрийн дохио, сэрэмжлүүлэх мэдээллийн агуулга, цаг үеэ олсон байдал, түүнчлэн харилцаа холбооны сувгийн сонголтыг авч үзнэ.

Үнэлгээг гурван жил тутам хөндлөнгийн эрх бүхий, мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж дүгнэлт гаргуулна.

Дүгнэлтээр шаардлага хангахгүй нь тогтоогдсон болон ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмжийг ашиглалтаас хасах эсвэл засвар үйлчилгээ хийж системийн бэлэн байдлыг хангана.

Аюулын дүн шинжилгээ нь дараах хүчин зүйлсийг агуулсан байна. Үүнд:

1. Зарлан мэдээлэл чиг үүрэгтэй байгууллага нь аюулт үзэгдлийн нөхцөл байдлын мэдээллийг эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүст хамгийн тохиромжтой хэлбэрээр тогтмол мэдээлэх;
2. Нөхцөл байдлын өөрчлөлтийг хүлээн авч, дамжуулах;

MNS 6980:2022

3. Эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүст учирч болох эрсдэлийн түвшнийг мэдээлэх.

5.3. Зарлан мэдээлэл дамжуулахад хүлээх эрх, үүрэг, хариуцлага

Зарлан мэдээлэх системийн оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага нь холбогдох хууль, дүрэм, журам, зааврын хүрээнд зохицуулагдана.

ТӨГСӨВ

A1 хавсралт
(норматив)

Зарлан мэдээлэл дамжуулах төрөл

Д/д	Мэдээлэл дамжуулах төрөл	“Улаан” түвшин	“Улбар шар” түвшин	“Шар” түвшин	“Ногоон” түвшин
1	Дуут дохиоллын цамхаг, техник хэрэгсэл	Түгшүүрийн дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “Анхаараарай, Анхаараарай, Анхаараарай ... (мэдээллийн товч утга)... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.	Сэрэмжлүүлэх дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.	Сэрэмжлүүлэх дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.	<ul style="list-style-type: none"> - Аюул өнгөрсөн тухай зөвлөмж хүргэх үеэр сургалтын дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “Онцгой байдлын ерөнхий газраас мэдээлж байна ... (мэдээллийн товч утга)”; - Сургалт, дадлагын үеэр зарлан мэдээллийн дохио дамжуулах дарааллыг 2 дугаар хавсралтад зааснаар; - Системийн техникийн туршилт хийх үеэр сургалтын дохиог 60 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа “Зарлан мэдээллийн системийн техникийн туршилт явагдаж байна” гэсэн мэдээллийг тодорхой давталттай дамжуулна.

2	Телевиз	Түгшүүрийн дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргахтай зэрэгцүүлэн бүтэн дэлгэцээр зарлан мэдээллийг хүргэх ба дэвсгэрийн өнгө улаан, бичвэрийн үсгийн өнгө хар байна.	Дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө улбар шар, бичвэрийн үсгийн өнгө хар байна.	Дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө шар, бичвэрийн үсгийн өнгө хар байна.	Дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө ногоон, бичвэрийн үсгийн өнгө хар байна.
3	Радио	“Анхаараарай, Анхаараарай, Анхаараарай ... (мэдээллийн товч утга)... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.	“Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.	“Иргэдийн анхааралд, ... (мэдээллийн товч утга)... Онцгой байдлын ерөнхий газар (Улсын онцгой комисс)” гэсэн загвараар мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.	<ul style="list-style-type: none"> - Аюул өнгөрсөн тухай зөвлөмж хүргэх үеэр “Онцгой байдлын ерөнхий газраас мэдээлж байна ... (мэдээллийн товч утга)”; - Сургалт, дадлагын үеэр “Гамшгаас хамгаалах сургалт дадлага явагдаж байгаа тухай мэдээллийн товч утга”; - Системийн техникийн туршилт хийх үеэр “Зарлан мэдээллийн системийн техникийн туршилт явагдаж байна” гэсэн мэдээллийг тодорхой давталттай дамжуулна.

A2 хавсралт
(норматив)

Сургалт, дадлагын үеэр зарлан мэдээлэл дамжуулах дараалал

д/д	Дохио	Дуут дохиоллын цамхаг			Телевиз	Радио	Гар утас
		Хугацаа	Цамхгийн чанга яригч	Цамхгийн лед дэлгэц			
1	Нэгдүгээр дохио	16:00-16:02	Сургалтын дохио <i>/120 секундийн турш тасралтгүй цацах/</i>	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль явагдаж байна. Иргэн та дадлага сургуульд идэвхтэй оролцоно уу. Онцгой байдлын ерөнхий газар	Дуут бичлэг Бүтэн дэлгэц Богино бичвэр	Дуут бичлэг	Мессеж
2		16:02-16:04	Дуут бичлэг дамжуулах Онцгой байдлын ерөнхий газраас мэдээлж байна. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль явагдаж байна. Иргэн та тайван байна уу. <i>/3 удаагийн давталттай/</i>				
3	Завсарлага	16:04-16:05	Завсарлага <i>/60 секунд/</i>		Завсарлага <i>/60 секунд/</i>	Завсарлага <i>/60 секунд/</i>	
4	Хоёрдугаар дохио	16:05-16:07	Сургалтын дохио <i>/120 секундийн турш тасралтгүй цацах/</i>		Дуут бичлэг Бүтэн дэлгэц Богино бичвэр	Дуут бичлэг	Мессеж
5		16:07-16:09	<u>Дуут бичлэг дамжуулах</u> Онцгой байдлын ерөнхий газраас мэдээлж байна. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль явагдаж байна. Иргэн та тайван байна уу. <i>/3 удаагийн давталттай/</i>		Богино бичвэр	-	
6	Завсарлага	16:09-16:11	Завсарлага <i>/120 секунд/</i>		Завсарлага <i>/120 секунд/</i>	Завсарлага <i>/120 секунд/</i>	
7	Гуравдугаар дохио	16:11-16:13	Сургалтын дохио <i>/120 секундийн турш тасралтгүй цацах/</i>		-	-	

8		16:13- 16:15	<p><u>Дуут бичлэг дамжуулах</u> Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд идэвхтэй оролцсон танд баярлалаа.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газар</p>	<p>Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд идэвхтэй оролцсон танд баярлалаа.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газар</p>	Богино бичвэр	Дуут бичлэг	Мессеж
---	--	-----------------	---	--	---------------	-------------	--------

Ном зүй

ISO 22322:2015, *Бүх нийтэд зарлан мэдээлэл дамжуулах заавар*

ISO 22324:2015, *Өнгөний кодоор зарлан мэдээлэл дамжуулах заавар*

ISO 22328-1:2020, *Олон нийтэд тулгуурласан байгалийн гамшгийн зарлан мэдээллийн системийг хэрэгжүүлэх заавар*

Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам (Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/292 дугаар тушаал)

Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар (Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/68 дугаар тушаал)